

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Халзан Дулаан ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/14/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 99029193
Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 9903 5990
Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК
Захирал: А.Сарангэрэл
Утас: 9988 4842
Цахим хаяг: gereltekhburtgelaudit03@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	7
4. Аудитын тайлан.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Дотоод хяналт.....	9
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
4.4 Материаллаг байдал.....	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	10
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
8. Аудитын илрүүлэлт.....	11
8.1 Төлбөрийн акт.....	11
8.2 Албан шаардлага.....	11
8.3 Зөвлөмж.....	11
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	13

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НӨАУГ	Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар

Аудитын санал дүгнэлт



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.16 № 143

танай _____-ны № _____-т

ЧОНОГОЛ ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.ТҮВШИНБИЛЭГ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд байгууллагын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/банкинд/	944,590.69	4,704,845.70
1.1.2	Дансны авлага		2,987,178.00
1.1.6	Бараа материал	2,391,928.00	2,200,556.50
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,336,518.69	9,892,580.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	406,932,865.34	404,548,712.98
1.2.2	Биет бус хөрөнгө	2,900,836.56	2,900,836.56
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	409,833,701.90	407,449,549.54
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	413,170,220.59	417,342,129.74
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	6,679,824.00	
2.1.1.3	Татварын өр	4,638,869.32	6,885,773.04
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	90,975,682.86	80,309,330.80
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	102,294,376.18	87,195,103.84
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	102,294,376.18	87,195,103.84
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	286,752,600.00	300,094,600.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	73,791,046.99	73,791,046.99
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	(49,667,802.58)	(49,667,802.58)
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(11,614,068.61)	5,929,181.49
2.3.11	Эздийн өмчийн дүн	310,875,844.41	330,147,025.91
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	413,170,220.59	417,342,129.74

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	160,250,139.87	198,549,814.10
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	160,250,139.87	198,549,814.10
8	Бусад орлого		10,050,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	17,621,100.00	92,510,119.81
10	Ерөнхий ба удирдлагын зардал	154,243,108.48	110,160,512.80
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(11,614,068.61)	5,929,181.49
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(11,614,068.61)	5,929,181.49
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(11,614,068.61)	5,929,181.49

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/				
Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний	286,752,600.00	73,791,046.00	(38,053,733.97)	322,489,912.03

Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

үлдэгдэл				
Залруулсан үлдэгдэл	286,752,600.00	73,791,046.00	(38,053,733.97)	322,489,912.03
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(11,614,068.61)	(11,614,068.61)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	286,752,600.00	73,791,046.00	(49,667,802.58)	310,875,843.42
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			5,929,181.49	5,929,181.49
Өмчид гарсан өөрчлөлт	13,342,000.00			13,342,000.00
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,094,600.00	73,791,046.00	(43,738,621.09)	330,147,024.91

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	178,055,710.87	220,620,665.06
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		220,620,665.06
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	178,055,710.87	210,570,665.06
	Бусад мөнгөн орлого		10,050,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	177,507,159.67	203,518,410.05
	Ажиллагчдад төлсөн	40,198,531.00	59,507,870.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	13,927,110.07	19,318,873.86
	Бараа материал худалдан авахад төлсөн	60,383,015.00	48,946,421.00
	Ашиглалтын зардалд төлсөн	4,548,427.80	5,353,714.57
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	38,327,483.00	48,561,955.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	20,122,592.80	21,738,635.62
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	50,800.00	90,940.0
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	548,551.20	17,102,255.01
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	13,342,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		13,342,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(13,342,000.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	548,551.20	3,760,255.01
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	396,039.49	944,590.69
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	944,590.69	4,704,845.70

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
A	Орлого төвлөрүүлэлт	160,250,100.00	160,250,100.00	188,499,814.06	28,249,714.06	117.6
	Бусад орлого			10,050,000.00	10,050,000.00	100
	Нийт дүн	160,250,100.00	160,250,100.00	198,549,814.06	38,299,714.06	117.6
	Цалин хөлс	42,939,600.00	42,939,600.00	59,507,900.00	16,568,300.00	138.6
	НДШ-ийн зардал	5,796,800.00	5,796,800.00	19,318,900.00	13,522,100.00	69.9
	Албан татвар хураамж /Машины татвар бусад/	20,122,592.80	20,122,592.80	18,413,706.95	(1,708,885.85)	91.5
	Бичиг хэргийн зардал	316,600.00	316,600.00	356,850.00	40,250.00	112.7
	Ашиглалтын зардал	4,548,427.00	4,548,427.00	5,353,714.57	805,287.57	117.7
	Хангамжийн материалын зардал	39,057,868.00	39,057,868.00	24,931,941.00	(14,125,927.00)	63.8
	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал	2,852,465.00	2,852,465.00	23,047,561.00	20,195,096.00	80.8
	Тогтмол үйлчилгээ, засвар	6,438,780.00	6,438,780.00	13,221,500.00	6,782,720.00	205.3
	Шатахууны зардал	16,016,005.00	16,016,005.00	10,711,116.00	(5,304,889.00)	66.9
	Даатгалын зардал					
	Утас, интернэт	350,000.00	350,000.00	300,000.00	(50,000.00)	85.7

Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Томилолт /унаа, буудал, хоол/	250,000.00	250,000.00	1,150,000.00	900,000.00	460
Банкны үйлчилгээний зардал	50,800.00	50,800.00	90,940.00	40,140.00	179
Хөдөлмөр хамгааллын зардал	1,379,500.00	1,379,500.00	991,000.00	(388,500.00)	71.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	2,149,000.00	2,149,000.00	6,541,750.00	4,392,750.00	67.1
Үндсэн хөрөнгө худалдаж авах зардал			13,342,000.00	13,342,000.00	100
Нийт дүн	154,243,100.00	154,243,100.00	192,620,632.57	38,377,500.00	124.9

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Халзан дулаан ОНӨААТҮГ-ын зорилго нь аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг дулаанаар хангахтай холбогдож үүссэн харилцааг зохицуулах, түүнд тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөр тооцооны нөхцөл болон хэрэглэгчийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох зорилготой, хамтын үйл ажиллагааг сайжруулан хэрэглэгчдийн эрх ашгийг хүндэтгэн дээдлэн хамгаалахад оршино.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 292 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-д тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тусгай зөвшөөрөл эзэмшигч-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийн зорилго нь Эрчим хүчний тухай хуульд заасан дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хэрэглэгчийг дулаанаар хангахтай холбогдож үүссэн гэрээний нөхцөл, түүнд тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, чанарын үзүүлэлт, төлбөр тооцооны нөхцөлийг тусгасан хэм хэмжээг тодорхойлоход оршино” гэж тодорхойлсон байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай байна. Өмчийг 100 хувь төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Сүхбаатар аймгийн Халзан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/07 дугаартай тогтоолыг үндэслэн Халзан дулаан ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй: ... 5/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;...” гэсэн заалттай нийцэж байна.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн Б/01 дугаартай тушаалаар Захирлыг томилсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Халзан дулаан ОНӨААТҮГ-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	944.6	4,704.8	3,760.2
Авлага	-	2,987.2	2,987.2
Бараа материал	2,391.9	2,200.6	191.3
Үндсэн хөрөнгө	406,932.9	404,548.7	2,384.2
Биет бус хөрөнгө	2,900.8	2,900.8	-
Нийт хөрөнгийн дүн	413,170.2	417,342.1	4,171.9
Богино хугацаат өглөг	11,318.7	6,885.8	4,432.9
Урьдчилж орсон орлого	90,975.7	80,309.3	10,666.4
Эздийн өмч	310,875.8	330,147.0	19,271.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	413,170.2	417,342.1	4,171.9

Банк дахь мөнгөний үлдэгдэлд Төрийн банкны харилцах дансанд байрших 4,704.8 мянган төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд Соёлын төв, сумын Засаг даргын Тамгын газраас авах нийт 2,987.2 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,200.6 мянган төгрөг болж, 191.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны зарцуулалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 404,548.7 мянган төгрөг болж, 2,384.2 мянган төгрөгөөр буурсан. Үндсэн хөрөнгийн данс худалдан авсан 2,432.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн.

Биет бус хөрөнгийн дансанд өөрчлөлт ороогүй, уг дансанд 990.0 мянган төгрөгийн программ хангамж, 2,997.0 мянган төгрөгийн байгууллагын эзэмшилтэй газар бүртгэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд НӨАТ-т өгөх 6,885.8 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/05 дугаар тушаалаар компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 160,250.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 154,243.1 мянган төгрөгөөр, 6,007.0 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 14,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 198,549.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 192,620.6 мянган төгрөгийн зардал гарган, 5,929.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 198,549.8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 38,299.7 мянган төгрөг буюу 23.9 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 192,620.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 38,377.5 мянган төгрөг буюу 24.9 хувиар илүү гүйцэтгэлтэй байгаа нь цалингийн зардал 16,568.3 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 13,522.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 4,392.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2 нэр төрлийн 1 ажилд өөрийн эх үүсвэрээс 13,342.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлж, төлөвлөснөөс 658.0 мянган төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр ашиг 5,929.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 77.8 мянган төгрөгөөр дутуу байгаа нь орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 38,299.7 мянган төгрөг буюу 23.9 хувиар давсан, зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 38,377.5 мянган төгрөг буюу 24.9 хувиар илүү гүйцэтгэлтэй байгаагаас шалтгаалжээ.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторов туслах Э.Алтангэрэл, аудиторов туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа, Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн Чанарын хяналтын менежер Д.Батмөнх, Захирал А.Сарангэрэл нар хэрэгжүүлсэн.

Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан тодруулгыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоос 2.0 хувиар буюу 6,378.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 5,102.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос 2.0 хувиар буюу 4,438.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 3,551.1 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 1,939.3 мянган төгрөгөөр буурсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ нь 2021 онд нийт 167,148.6 мянган төгрөгийн 25 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 98,767.8 мянган төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6.2. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 100,911.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,053.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,090.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 98,767.9 мянган төгрөгийн зөвлөмж, үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөвлөмж өгөв.

8.1 Төлбөрийн акт

1. Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 1 ажилтны 7-12 сарын НДШ-ийг энгийн ажилтны хувиар тооцсоноос 73.3 мянган төгрөгийг илүү, ХХОАТ чөлөөлөлгүй тооцсоноос 979.8 мянган төгрөгийг илүү суутгасан;

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

8.2 Албан шаардлага

Байгууллага нь нийт 3 хувь хүнтэй холбоотой 1,090.0 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 10 ширхэг 18,104.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 167,148.6 мянган төгрөгийн 25 мэдээллийг ил тод байршуулахаас 98,767.9 мянган төгрөгийн 10 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Цалинг буруу тооцоолж олгосон	1	1,053.1			1	1,053.1				
2	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	1,090.0							1	1,090.0
3	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		3	2,143.1	-	-	1	1,053.1	-	-	2	1,090.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	98,767.9							1	98,767.9
Дүн		1	98,767.9	-	-	-	-	-	-	1	98,767.9
Нийт дүн		4	100,911.0	-	-	1	1,053.1	-	-	3	99,857.9

